

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ДУГААР 151011-1
ХАВСРАЛТ
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн 14:00–16:00 цагт Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхрын хурлын танхимд хуралдуулав.

Хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн дарга А.Ганхуяг, Хурлын Тооллогын комиссоор Голомт Капитал ХХК-ийн Хөрөнгө оруулалтын шинжээч Б.Тэлмэн (дарга), Брокер Ж.Мөнхзаяа, Брокер Э.Намуунаа нар, Хурал зохион байгуулах комиссоор Санхүүгийн газрын захирал С.Дашдорж (дарга), ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга, Маркетингийн газрын захирал Г.Батбаатар, Комплайнс менежер Г.Энхтуяа нар тус тус ажиллав. Хуралд ТУЗ-ийн гишүүд О.Батмөнх, Г.Бат-Эрдэнэ, Г.Чинзориг, Б.Бат-Эрдэнэ, Н.Энхболд, Гари Стивен Биондо нар мөн оролцов.

Хурлын дарга Тооллогын комиссын даргаас хурлын ирцийг танилцуулахыг хүсэв. Хуралд Компанийн 690,015,848 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид оролцож Компанийн нийт саналын эрх бүхий 817,768,643 ширхэг энгийн хувьцааны 84.38 хувь болж байгааг Хуралд оролцогч хувьцаа эзэмшигчдэд болон Хурлын даргад мэдээлж Компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 84.38 хувийг эзэмшигчид Хуралд оролцож байгаа тул Хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Хурлыг нээж, Хурлын дэг болон Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Хурлаар танилцуулах асуудалд:

- (i) Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
- (ii) Компанийн 2021 оны санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
- (iii) Компанийн 2021 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах;

Хурлаар хэлэлцэх асуудалд:

- (i) Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- (ii) Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн ердийн гишүүдээр сонгох. Үүнд:
 - (a) Адилбиш овогтой Ганхуяг;
 - (б) Адилбиш овогтой Ганболд;
 - (в) Гансүх овогтой Бат-Эрдэнэ;

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

- (г) Очирбат овогтой Батмөнх;
- (д) Ганболд овогтой Чинзориг, болон
- (е) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ;
- (iii) Дор дурдсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн хараат бус гишүүдээр сонгох. Үүнд:
 - (а) Нямжав овогтой Энхболд;
 - (б) Чулуун овогтой Мэргэн; болон
 - (в) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).

Хурлын дарга Тооллогын комиссыг Хуралд санал өгөх журмыг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлаар хэлэлцэх 1 дүгээр асуудлыг ердийн аргаар санал хураах ба хувьцаа эзэмшигчид нь эдгээр асуудалд "Зөвшөөрсөн", "Татгалзсан" эсвэл "Түдгэлзсэн" ээ илэрхийлж харгалзах нэг нүдэнд ☒ тэмдэглэгээг хийж санал аа өгөх, харин Хурлаар хэлэлцэх 2 дугаар асуудлыг кумулятив аргаар санал хураах тул хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байж хувьцаа эзэмшигчид саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй тухай танилцуулав.

Хурлын дарга танилцуулах болон хэлэлцэх асуудал тус бүрийг танилцуулахыг Хурал зохион байгуулах комиссын даргаас хүсэв. Хурал зохион байгуулах комиссын дарга нь Хуралтай холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох үүднээс Хурлын зарыг 2022 оны 03-р сарын 02-ны өдөр, давтан зарыг 2022 оны 03-р сарын 17-ны өдөр тус тус Өнөөдөр сонин, Өдрийн сонин, Компани болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн цахим хуудсаар, мөн Хурлын танилцуулга материал буюу Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн 2022 оны 02-р сарын 25-ны өдрийн 151021-5 тоот тогтоол, Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэрийн төсөл, ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга, Хуралд урьдчилан цахимаар санал өгөх заавар болон Хуралд оролцож, санал өгөх зааврыг 2022 оны 03-р сарын 02-ны өдөр Компанийн цахим хуудаст байршуулж, брокерын компаниуд болох Голомт Капитал ХХК, Апекс Капитал ХХК-д хүргүүлснийг дурдаад дараахыг танилцуулав.

1. КОМПАНИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг Компанийн 2021 оны онцлох зүйлс, дэлгүүрийн тоо, үйлчлүүлэгчдийн тоо (давтагдсан), системийн борлуулалт, цэвэр орлого, харьцуулагдахуйц дэлгүүрийн борлуулалтын индекс, цэвэр алдагдлын хувь, үйл ажиллагааны цар хүрээ, стратегийн зорилтуудын гүйцэтгэл болон байгаль орчин, нийгэм, засаглалын тайлангийн талаар танилцуулав.

Компанийн Санхүүгийн газрын захирал С.Дашдорж 2021 он болон 2022 оны 1-р улирлын санхүүгийн үзүүлэлт, санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн санхүүгийн тайланг танилцуулав.

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

Хурал зохион байгуулах комиссын дарга Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны тайлантай холбоотой асуулт байгаа эсэхийг асуув. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс дараах асуултуудыг асууж Компанийн удирдлагын зүгээс холбогдох хариултуудыг өгөв.

Асуулт 1: Борлуулалтын өртөгт ямар зардлууд орсон, хөрөнгө оруулалтын зардлыг оруулсан эсэх, салбар дэлгүүр шинээр нээхэд зарцуулсан хөрөнгө оруулалтын зардлыг капитал зардалд бус үйл ажиллагааны урсгал зардалд бүртгэж байгаа юу? Борлуулалтын өртөг болон бараа материалын өртгийн хоорондын зөрүү хэд байгаа вэ?

Хариулт 1: Компанийн үнэт цаасны танилцуулгад орсон хараат бус аудиторын дүгнэлт болон тодруулгуудаас борлуулалтын өртөгт орсон зардлуудын задаргааг харах боломжтой. Борлуулалтын өртөгт хөрөнгө оруулалтын зардлыг тусгадаггүй харин бараа материалын өртгөөс гадна түрээсийн төлбөр, ажилчидтай холбоотой зардал, тог цахилгааны зардал гэх мэт дэлгүүр дээр гарч байгаа бүх зардлыг тусгаж оруулдаг. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хөрөнгө оруулалтын зардлыг борлуулалтын өртөгт шууд тусгаж болохгүй. Харин дэлгүүртэй холбоотой бүтээн байгуулалтын элэгдлийн зардал үйл ажиллагааны зардалд тусгагддаг тухай Компанийн Санхүүгийн газрын захирал С.Дашдорж хариулав.

Асуулт 2: Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 27 тэрбум төгрөг гэсэн. Эздийн өмч өмнөх онтой харьцуулахад 60-аад тэрбум төгрөгийн өсөлт харагдаж байна. Яагаад ийм зөрүүтэй байгаа вэ?

Хариулт 2: Компани олон нийтийн компани болохоос өмнө бүтцийн өөрчлөлт хийсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор өмнөх толгой компани болох Премиум Групп ХХК-ийн зүгээс хоорондын тооцоогоорх өглөгөө эздийн өмчрүү шилжүүлж хаасан зэрэг нэмэгдүүлэлт болон Солонгос хөрөнгө оруулагчийн зүгээс нэмж хөрөнгө оруулалт хийгдсэн гэх мэт өөрчлөлтүүд гарсан. Энэ нь Компанийн хувьцааг олон нийтэд санал болгох (IPO)-ын өмнөх эздийн өмчийн бүрдэлд харагдана. Харин IPO хийснээр татан төвлөрүүлсэн 28.6 тэрбумын төгрөгөөс андеррайтерын үйлчилгээний шимтгэл хасагдсан дүнгээр эздийн өмч нэмэгдэж, мөн IPO санхүүжилт татахтай холбогдох үйл ажиллагааны зардлыг хасаж тооцвол цэвэр дүнгээр 27 тэрбум төгрөгийн санхүүжилтийн цэвэр орох урсгал бий болсон гэж Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Асуулт 3: Дэлгүүрийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг 22 хувиар багасгасан гэсэн. Ямар арга хэмжээ авсны үр дүнд багасгаж байгаа вэ? Мөн ажилчдын сургалт, зохион байгуулалтын талаар мэдээлэл өгнө үү?

Хариулт 3: Ажилчид хийж байгаа ажилдаа сэтгэл ханамж өндөр байх хэрэгтэй бөгөөд сэтгэл ханамж өндөр байхад цалин, шууд удирдлага гэх мэт олон хүчин зүйл нөлөөлж байна. Шууд удирдлагаас болж олон хүн ажлаасаа гардаг тул Компанийн зүгээс дэлгүүрийн менежерүүдийг ур чадвартай болгох, дэлгүүрийн менежерүүдийг удирддаг хүмүүсийг ур чадвартай болгох, цаашлаад нийт ажилчдын ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажилладаг. Мөн хүн болгон ажил дээрээ карьерын хувьд өсөж дээшлэх хүсэлтэй байдаг ба Компанийн зүгээс карьерыг хөгжүүлэх системийг нэвтрүүлсэн. Тиймээс карьерыг хөгжүүлэх систем болон сургалтуудын үр өгөөж нь хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг багасгахад гол нөлөөлсөн хүчин зүйл байгаа.

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

Ковидын үед сургалтыг цахимаар явуулж байсан ба энэ жилээс танхимаар зохион байгуулж байна. Ингэснээр сургалтын үр дүн сайжирна гэж харж байна хэмээн Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзориг хариулав.

Асуулт 4: Компанийн зүгээс ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэх бодлого барих уу? Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хөрөнгө оруулагч залуучуудын дундаас сонгон шалгаруулах замаар ТУЗ-ийн гишүүдийг сонгох бодлого байдаг уу эсвэл зөвхөн өөрсдийн танилын хүрээнээс сонгох бодлоготой юу?

Хариулт 4: Ихэнх компанийн хувьд ТУЗ нь хувьцаа эзэмшигчид, ялангуяа хамгийн өндөр хувь эзэмшиж байгаа хүмүүсийн төлөөллөөс бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл, Компанийг ашигтай ажиллуулахын төлөө бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллаж чадах хүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгох хэрэгтэй. Компанийн хувьд эдгээр нэр дэвшигчид дотроос сонгон шалгаруулалт хийж өргөн хүрээний туршлага, мэргэшил, мэдлэг, ур чадвартай хүмүүсийг ТУЗ-ийн гишүүнээр сонгох бодлого баримталж ажилладаг. Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүд байх хэрэгтэй. Хараат бус гишүүдийг сонгох үндсэн шалтгаан бол Компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах явдал юм. Нөгөө талаас Компани олон нийтийн компани болсон учраас нийгэм болон байгаль орчинд нөлөөлөл үзүүлэхүйц хэмжээнд үйл ажиллагаа нь өргөжин тэлж байна. Тийм учраас ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгохдоо энэ тал дээр туршлагатай, чадварлаг хүмүүсийг сонгодог тухай ТУЗ-ийн дарга А.Ганхуяг хариулав.

Асуулт 5: Ихэнх компаниуд татварт бага дүн төлөх шалтгаанаар дансны үнэ буюу нийт хөрөнгөөс өр төлбөрийг хассан эздийн өмчийг нийт хувьцаанд хуваасан дүнг зах зээлийн үнээс бага гаргадаг. Энэ нь тухайн компанийн хувьцааг худалдаж авч байгаа эрэлтийг бага болгож харагдуулдаг. Иймд Компанийн дансны үнэ хэд байгаа болон зах зээлийн үнэтэй харьцуулахад ямар зөрүүтэй байгаа вэ? Компанийн нийт хөрөнгийн дүнг хэр үнэн зөв гаргасан бэ?

Хариулт 5: Компанийн санхүүгийн тайлан дээр тусгагдсан нэгж хувьцааны дансны үнэ болон арилжаалагдаж буй зах зээлийн үнэ бол хоёр өөр ойлголт байдаг. Олон нийтийн компани болохоос өмнө хөндлөнгийн үнэлгээний байгууллага Компанийн бизнесийн ба хувьцааны үнэлгээг гүйцэтгэсэн бөгөөд бизнесийн үнэлгээний дүнгээс өр төлбөрийг хасах замаар нэгж хувьцааны зах зээлийн үнийг 208 төгрөг, нийт хувьцааны зах зээлийн үнэлгээг 168 тэрбум төгрөг гэж тооцсон. Компанийн зах зээлийн үнэлгээг ирээдүйд бий болгох бизнесийн ашиг орлогоос өнөөдөр рүү татаж харах байдлаар гаргадаг бөгөөд энэ ойлголтоор бол дийлэнх амжилттай бизнесийн хувьд зах зээлийн үнэ нь дансны үнээс өндөр гардаг. Өчигдрийн хаалтын ханшаар Компанийн хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ 173 тэрбум төгрөг байсан бол нийт хувьцааны дансны үнэ буюу эздийн өмчийн дүн нь 2022 оны 03-р сарын 31-ний тайлангаар 40 тэрбум төгрөг байгаа. Энэ хоёр дүнгийн хооронд 4 дахин ялгаа харагдаж байгаа бөгөөд олон улсын хөрөнгийн зах зээл дээрх ижил төстэй компаниудын тус харьцаа дунджаар 5-аас 9 дахин ялгаатай байдаг тухай Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Асуулт 6: Өнөөдрийн байдлаар 200 салбар нээгдсэн бөгөөд цаашид 360 хүртэл салбар дэлгүүр нээх төлөвлөгөөтэй гэж танилцуулсан. CU салбар дэлгүүрүүдийн тоо олон болохоор зах зээлийн

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

зарчмаар бусад жижиглэнгийн худалдаа эрхэлдэг дэлгүүрүүд хаагдана. Тэгэхээр СУ конвиниенс дэлгүүр дангаараа хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг 100 хувь хангаж чадахгүй, асуудал үүсэхээр харагдаж байна. Энэ тал дээр ямар бодолтой байна вэ?

Хариулт 6: Улаанбаатар хотод амьдарч буй хүмүүсийн өдөр тутам үйлчлүүлдэг хүнсний дэлгүүр, хоолны газар, кофе шоп зэрэг бидний үзүүлдэг үйлчилгээтэй төстэй үйлчилгээ үзүүлдэг нийт 7000 орчим цэг байдаг. Тэгэхээр зах зээлийн багтаамж өндөр харагдаж байна. Нөгөө талдаа бусад жижиглэнгийн худалдаа эрхэлдэг дэлгүүрүүдтэй харьцуулахад манай Компани их татвар төлж, олон ажлын байрыг үүсгэж, олон хүнийг сургаж, олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна гэдэг утгаараа нийгэмдээ илүү сайн үр нөлөөг авчирч байна гэж Компанийн Гүйцэтгэх захирал хариулав.

Асуулт 7: Олон нийтээс татан төвлөрүүлсэн санхүүжилтийн 8.2 тэрбум нь богино хугацаат хөрөнгө оруулалтад зарцуулагдсан гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Хариулт 7: Компани хувьцаагаа олон нийтэд санал болгох байдлаар 2021 оны 11 сарын 03-ны өдөр санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн бөгөөд Компанийн дансанд өмнө хэлсэнчлэн 27 тэрбум төгрөг цэвэр дүнгээр орж ирсэн. Алдагдсан боломжийн өртгийг тооцоолон уг санхүүжилтийг Компанийн банк дах харилцах дансанд маш бага хүүтэй, эсвэл тэг хүүтэй байлгахын оронд Монгол Улсын топ түвшний үнэт цаасны андеррайтер, брокерын компаниуд болох Ти Ди Би Секьюритис ҮЦК, Голомт Капитал ҮЦК компаниудтай хамтарч ажиллах замаар тэдгээр компаниудын гаргасан бондуудыг эрсдэлийг нь Компани үүрэхгүйгээр буюу хугацаа, өгөөж тохирон репо нөхцөлөөр брокер, дилерт буцаан худалдах нөхцлөөр хөрөнгө оруулалт хийсэн. Энэ талаар дэлгэрэнгүй танилцуулгыг хөрөнгө оруулагчидтай хийх дараагийн улирлын уулзалтын үеэр мэдээлнэ гэж Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Асуулт 8: Компани байгуулагдаад 3.5 жил болж байна. Саяхан 2021 оны хавраас GS25 гэх өрсөлдөгч гарч ирсэн бөгөөд энэ компани нь байгуулагдаад жил хүрэхгүй хугацаа болоход зах зээлд эзлэх байр суурь нь хурдан нэмэгдэж байна. Компанийн зүгээс өрсөлдөгчөө яаж харж байна вэ? Зах зээлд эзлэх байр сууриа хэрхэн хэвэнд нь хадгалах болон энэ талаар авч хэрэгжүүлж байгаа бодлогын талаар мэдээлэл өгнө үү?

Хариулт 8: Манай өрсөлдөгч болох GS25 нь 55 салбар дэлгүүртэй, СУ нь нийт 200 салбар дэлгүүртэй байна. Шинээр салбар дэлгүүр нээж байгаа хурдыг харьцуулбал бид 1.5 дахин илүү байгаа бөгөөд Компанийн хувьд хурдаараа хоцрохгүй. Хамгийн чухал стратеги бол зах зээлд түрүүлж байр сууриа эзлэх явдал юм. Үйлчилгээний чанартай холбоотой асуудлууд дээр Компанийн зүгээс бүх төрлийн судалгаанууд хийн өөрийн сул болон давуу талуудаа тодорхойлж, давуу талаа хэрхэн хадгалах, сул талаа хэрхэн сайжруулах талаар бодлого, стратеги боловсруулан ажиллаж байна. Компанийн менежментийн баг үйлчлүүлэгчдийнхээ дуу хоолойг сонсох, илүү объектив судалгаанууд хийх замаар дэлгүүрээ үйлчлүүлэгчдийнхээ нүдээр бодитой харах нь хамгийн чухал стратеги гэж үздэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс мөн үйлчилгээний чанартай холбоотой асуудлуудад ач холбогдол өгдөг. ТУЗ-ийн дэргэдэх Байгаль орчин, нийгэм, засаглал ("БОНЗ")-ын хороонд үйлчилгээний чанартай холбоотой асуудлуудаа тайлагнаж, зөвлөгөө авдаг гэж Компанийн Гүйцэтгэх захирал хариулав.

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

Хурлаар танилцуулсан 1-р асуудалтай холбоотой асуулт, хариултын хэсэг дууссаныг Хурал зохион байгуулах комиссын дарга мэдэгдэв. Компани нь олон нийтийн компани болсноос хойш 5 сарын хугацаа өнгөрсөн бөгөөд хариуцлагатай, ил тод компани байхын төлөө зорин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд улирал бүр санхүү, үйл ажиллагааны үр дүнгээ Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК дээр шинжээчдээр дамжуулан тайлагнаж байгаа бөгөөд цаашдаа хувьцаа эзэмшигчдээс нээлттэй цонхоор асуулт авах, хариулт өгөх боломжийг нээн ажиллана гэдгээ та бүхэнд дуулгая гэж Компанийн Санхүүгийн газрын захирал хэлэв.

2. КОМПАНИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ

Компанийн хараат бус аудитор ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК-ийн Партнер Шаукат Тапия болон менежер Б. Билгүүн аудитын дүгнэлт, юунд аудит хийсэн талаар, дүгнэлтийн үндэс, хараат бус байдал, аудитын арга барил, аудитын гол асуудлууд болон бусад мэдээлэл гэсэн сэдвийн хүрээнд Компанийн 2021 оны санхүүгийн жилийн тайлангийн хараат бус аудиторын тайланг танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга Компанийн 2021 оны санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлттэй холбоотой асуулт байгаа эсэхийг асуув. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс дараах асуултуудыг асууж Компанийн удирдлагын зүгээс холбогдох хариултуудыг өгөв.

Асуулт 9: Компани олон нийтээс татан төвлөрүүлсэн санхүүжилтээс 8.2 тэрбум төгрөгийг богино хугацаат хөрөнгө оруулалтад зарцуулсан нь холбогдох хууль журамтай нийцэж байгаа юу? Үнэт цаасны тухай хуульд олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг өөр зүйлд зарцуулж болохгүй гэсэн зохицуулалт байдаг. Энэ асуудал дээр тодруулга өгнө үү?

Хариулт 9: Алдагдсан боломжийн өртгийг тооцоолон олон нийтээс татан төвлөрүүлсэн санхүүжилтийг Компанийн дансанд байлгахын оронд эрсдэл үүрэхгүйгээр, богино хугацаатай бонд худалдан авсан тухай өмнө нь хэлсэн. Тухайн үед банкны богино хугацаатай овернайт хадгаламжийн хүү жилийн 1.2 хувь байсан бол бондын хүү 14 орчим хувь байсан. Зориулалтын дагуу захиран зарцуулах хүртэлх хугацаанд буцаан худалдах нөхцөлтэй бонд худалдан авсан талаар мэргэжлийн байгууллагуудаас зөвлөмж авч, мэдээлэл өгсөн. Нэмж хэлэхэд ирэх долоо хоногтоор дуусгавар болгоод худалдан авсан бүх бондуудаа зарж дуусч байгаа гэж Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Асуулт 10: Компани үүсгэн байгуулагдсанаасаа хойш дандаа алдагдалтай ажилласан. Татварын тухай хуулиараа дараагийн 3 жилд хэрэв ашигтай ажиллавал, ашигтай ажилласан жилээсээ авхуулаад татвараас хөнгөлөгдөх нөхцөлүүд үүснэ гэж ойлгосон зөв үү?

Хариулт 10: 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөс хойш хуулиар бол Компанийн татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлэх хугацаа нь 4 жил байгаа. Өөрөөр хэлбэл, 2020, 2021 оны

ДУГААР 151011-1

ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

санхүүгийн алдагдалд суурилан 2023, 2024, 2025 онуудад ашигтай ажиллавал ирэх жилүүдэд төлөх татвараа тухайн жилийнхээ төлөх дүнгээс 50 хувиар хэмнэх боломжтой бөгөөд Компанид одоо байгаа ашиглагдах боломжтой нөөц сан нь 2.5 тэрбум орчим төгрөг байна гэж Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Асуулт 11: СУ дэлгүүрүүд дээр оюутан хүүхдүүд авч ажиллуулдаг ба тэдгээрийн дунд цалингаа өгдөггүй, бараа бүтээгдэхүүний хорогдлыг цалингаас нь шууд суутгадаг, ерөнд ордог гэх мэт яриа гардаг. Үүнээс харахад дэлгүүрийн ажилчдын сэтгэл ханамж муу, шилжих хөдөлгөөн өндөр, Компанийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл байна. Энэ асуудал дээр ямар арга хэмжээ авч байгаа болон барааны хорогдлыг хэрхэн шийдвэрлэдэг талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Хариулт 11: Жижиглэн худалдааны бизнест үүсдэг эрсдэлүүдэд таны хэлсэн эрсдэл орно. Дэлгүүрийн ажилтнуудыг ямар ч буруугүй байхад нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хариуцлага тооцдог тогтолцоо Компанид байхгүйг хариуцлагатайгаар мэдэгдье. Зөрчил нь баримтаар нотлогдсон тохиолдолд Компанийн зүгээс тодорхой хариуцлага тооцдог. Үнэлгээний хувьд энэ бүх статистикууд санхүүгийн тайлан болон үнэлгээний тайланд тусгагдаад явдаг хэмээн Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Компани нь маш хариуцлагатай ажил олгогч бөгөөд ажилчдын цалин дээр аль болох алдаа гаргадаггүй, цалингаа цагт нь олгож, ажилчдын гүйцэтгэл нь шударгаар үнэлэгддэг. Дэлгүүрийн ажилчид ерөнд орж байгаа гэсэн таны асуулт дээр тайлбар хэлэхэд Монгол Улсын жижиглэнгийн худалдааны бүх компаниуд бараа бүтээгдэхүүний дутагдал, хорогдлыг цалингаас хасаж тооцож байгаа. Энэ систем нь ажилчдын өнцгөөс харвал шударга бус систем гэж бид үздэг учраас Компанийн зүгээс тодорхой хувь хэмжээг төсвөөрөө хүлээн зөвшөөрч, тогтоосон хувь хэмжээнээс хэтэрвэл хариуцлага тооцох асуудлыг авч үздэг. Энэ нь Монголын зах зээл дээр ажил олгогчийн талаас харвал хамгийн шударга систем гэж бодож байна хэмээн Компанийн Гүйцэтгэх захирал хариулав.

3. КОМПАНИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)-ААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭР, ТҮҮНИЙ ШАЛТГААН

2022 оны 02-р сарын 10-ны өдөр Сангийн яаманд хүргүүлсэн Компанийн санхүүгийн тайланд үндэслэн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ногдол ашгийн бодлогын дагуу Компанийн ТУЗ-өөс 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн 3 тоот тогтоолоор 2021 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Компани ашигтай ажилласан жилээс эхлэн ногдол ашиг хуваарилахыг ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. 2021 оны санхүүгийн үр дүнгээр Компани алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй гэсэн шийдвэр гаргасан тухай Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга Компанийн 2021 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгаантай

ДУГААР 151011-1

ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

холбоотой асуулт байгаа эсэхийг асуув. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн зүгээс дараах асуултуудыг асууж Компанийн удирдлагын зүгээс холбогдох хариултуудыг өгөв.

Асуулт 12: 2022 оны 03-р сарын 31-ний өдрийн байдлаар ТУЗ-ийн гишүүдийн Компанид эзэмшиж буй хувьцааны талаар мэдээлэл өгнө үү? IPO хийсний дараа өөрчлөлт гарсан уу?

Хариулт 12: 2021 оны 11-р сарын 03-ны өдөр буюу Компани хувьцаагаа анхдагч зах зээл дээр олон нийтэд санал болгосон өдрөөр Компанийн өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувьцааг арилжаалагдах боломжгүйгээр тусгаарласан. Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 16.7 орчим хувийг олон нийтээс татан төвлөрүүлсэн бөгөөд зөрүү дүн нь өмнөх хувьцаа эзэмшигчид буюу Монгол улсын иргэн хүмүүс болон БНСУ-ын хувьцаа эзэмшигч БиЖиЭф Ритэйл компанийн эзэмшилд хэвээрээ байгаа гэж Компанийн Санхүүгийн газрын захирал хариулав.

Асуулт 13: Охин компани нь их ашиг хийгээд толгой хувьцаат компани нь ашиггүй ажилладаг тохиолдлууд байдаг. Иймд Компанийн эзэмшилд охин компани байдаг эсэх байдаг бол ямар үйл ажиллагаа эрхэлдэг, ямар үүрэгтэй вэ?

Хариулт 13: Компани хувьцаагаа олон нийтэд санал болгохоос өмнө хоолны үйлдвэр, түгээлтийн төвийн үйл ажиллагааг эрхэлдэг компанийг Компанийн 100 хувийн охин компани болгон нэгтгэсэн байгаа. Та бүхэнд танилцуулж байгаа санхүүгийн үр дүн бол нэгтгэсэн байдлаар танилцуулагдаж байгаа бөгөөд нэг компаниас нөгөө компани руу ашгийг шилжүүлэх гэсэн нөхцөл байхгүй гэж Компанийн Гүйцэтгэх захирал хариулав.

Асуулт 14: Өнгөрсөн онд ашиггүй ажилласан учраас ногдол ашиг хуваарилахгүй гэж танилцууллаа. Санхүүгийн алдагдалтай ажиллаж байгаа тул Компанийн удирдлагын багтай хариуцлага тооцох талаар ярихгүй юу?

Хариулт 14: Уур амьсгал нэгнийгээ зэмлэх хандлагатай хувьцаа эзэмшигчдийн хурал байж болохгүй. Компани нь хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгох үед Компанийн ирээдүйд олох мөнгөн урсгал дээр үндэслэн өнөөгийн үнэ цэнийг тооцон бизнесийн талаарх бүх дүгнэлтийг тусгасан Үнэт цаасны танилцуулгыг гаргасан. 2021 онд алдагдалтай ажиллана гэдгээ Компани мэдэж байсан бөгөөд мөнгөн урсгалын төлөвлөгөөнд суучихсан байсан. Компани нь маш гоё зах зээл дээр өөрийн гэсэн онцлогтой, сонирхолтой үйлчилгээг бий болгож байгаа өндөр өсөлттэй компани юм. Компанийн удирдлагын баг нь өндөр хариуцлагыг үүрч, маш их хүчин чармайлт гаргаж ажилласнаар Компанийн бизнесийг өнөөдрийн түвшинд авчирсан. Үнэт цаасны танилцуулгад орсон үйл ажиллагаа болон санхүүгийн төлөвлөгөөнөөс 2021 оны гүйцэтгэл нь бага байсан тохиолдолд хариуцлага тооцох асуудал яригдана. Өнөөдөр та бүхэнд танилцуулсан 2022 оны 1-р улирлын гүйцэтгэлийг Үнэт цаасны танилцуулгад орсон төлөвлөгөөтэй харьцуулахад хамаагүй өндөр үр дүн үзүүлсэн байна. Иймд хүн болгон санхүүгийн нарийн мэдлэг, мэдээлэлтэй байх албагүй ч хөрөнгө оруулалт хийх гэж буй компанийнхаа Үнэт цаасны танилцуулгатай маш сайн танилцаж байж хөрөнгө оруулалт хийдэг байгаасай гэж хүсэж байна. Бид олон нийтийн компани буюу нээлттэй, ил тод компани болсон учир манай өрсөлдөгч Компанийн хөрөнгө оруулагч болох боломжтой. Хурлаар асууж байгаа асуултууд дотор өрсөлдөгчийн нүдээр харж асууж байгаа асуултууд байна. Энэ бол шударга, байх ёстой зүйл. Эцэст нь, Компанийн хувьцаа

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

эзэмшигчдийн төлөөлөл болох миний зүгээс менежментийн багт маш их баярлалаа гэж хэлмээр байна гэж ТУЗ-ийн дарга хариулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга Хурлаар хэлэлцэх 2 асуудлыг танилцуулав.

4. КОМПАНИЙН 2021 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 болон Компанийн Дүрмийн 9.4.9-р заалтыг тус тус үндэслэн Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дараах дүгнэлтийг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

2021 оны 11-р сард Компанийн хувьцааг олон нийтэд санал болгож шаардлагатай санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж чадсан нь бизнесийн богино, дунд, цаашлаад урт хугацааны үр дүнд томоохон эерэг нөлөөг үзүүлэх үйл явдал болжээ. 2021 он коронавирусын өндөр тархалт, хөл хорио, тээвэр логистикийн гацаа, үнийн өсөлт зэрэг олон хүндрэл, асуудалтай жил байсан хэдий ч Компани хувьцаа эзэмшигчдэдээ амласандаа хүрч нийт 94 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалтын орлоготой ажиллаж төлөвлөгөөгөө 6.2 хувиар давуулан биелүүлсэн, цэвэр алдагдал 18 тэрбум төгрөгт хүрсэн нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн төлөвлөгөөнөөс 10 хувиар сайн гүйцэтгэлтэй гарсан. Мөн, СУ сүлжээ дэлгүүрийн тоог 63-р нэмэгдүүлж, тайлант оны эцэст өдөр бүр 60 мянган хүн үйлчлүүлдэг 165 салбар дэлгүүртэй болжээ.

Компани нь 2021 онд 1,855 хүнийг ажлын байраар хангаж, нийт 16 орчим тэрбум төгрөгийн цалин урамшууллыг олгосон байна. Мөн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг хийлгэсэн бөгөөд Олон Улсын Санхүүгийн Корпорацын Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан 182 шалгуур үзүүлэлтийг суурь үнэлгээ болгон авч үзсэнээс нийт 174 шалгуурыг бүрэн хангаж 95.6 хувийн биелэлттэй гарсан.

Иймд Компанийн Гүйцэтгэх удирдлагын баг 2021 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна хэмээн Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

5. КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙГ СОНГОХ

Компанийн Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн 9-н гишүүнтэй, гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар заасан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүн Р.Ганболд нь өөрийн хүсэлтээр 2022 оны 01-р сарын 28-ны өдөр чөлөөлөгдөж түүний оронд Н.Энхболдыг ТУЗ-өөс түр томилсонтой холбогдуулан Компанийн тухай хуулийн холбогдох заалтуудыг үндэслэн ТУЗ-ийн гишүүдийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож шинэ бүрэлдэхүүнээр буюу Адилбиш овогтой Ганхуяг, Адилбиш овогтой Ганболд, Гансүх овогтой Бат-Эрдэнэ, Очирбат овогтой Батмөнх, Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ, Ганболд овогтой Чинзориг нарыг ТУЗ-ийн ерийн гишүүнд, Нямжав овогтой Энхболд, Чулуун овогтой Мэргэн, Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнд тус тус нэр дэвшүүлж байгаа

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

тухай болон нэр дэвшиж буй гишүүдийн товч намтрыг Хурал зохион байгуулах комиссын дарга танилцуулав.

Хурал зохион байгуулах комиссын дарга санал хураалтыг эхлүүлэв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Тооллогын комиссыг Хурлын санал хураалтын дүнг танилцуулахыг хүсэв. Тооллогын комиссын дарга Хурлын санал хураалтын дүнг дараах байдлаар Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдэд мэдээлэв. Үүнд:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах: зөвшөөрсөн 687,326,072 ширхэг хувьцаа буюу 100 хувь, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 хувь, түдгэлзсэн 3,058 ширхэг хувьцаа буюу 0 хувь байна.
2. Компанийн ТУЗ-ийн гишүүнээр сонгуулахаар нэр дэвшсэн хүн тус бүрээр өгсөн саналын тоо нь дор дурдсан тоо хэмжээтэй байна.

№	ТУЗ-ийн гишүүд	Саналын тоо	Саналын хувь
Ердийн гишүүд			
1	Адилбиш овогтой Ганхуяг	691,206,560	11.17 %
2	Адилбиш овогтой Ганболд	687,306,527	11.11 %
3	Гансүх овогтой Бат-Эрдэнэ	686,846,924	11.10 %
4	Очирбат овогтой Батмөнх	686,329,054	11.09 %
5	Ганболд овогтой Чинзориг	687,063,233	11.11 %
6	Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ	685,911,859	11.09 %
Хараат бус гишүүд			
1	Нямжав овогтой Энхболд	686,631,718	11.10 %
2	Чулуун овогтой Мэргэн	686,755,638	11.10 %
3	Гари Стивег Биондо (Gary Stephen Biondo)	687,910,657	11.12 %

Хурлын дарга санал хураалтын дүнтэй танилцаад хурлаас дараах шийдвэрүүд гарсан тухай танилцуулав. Үүнд:

Тогтоол 1: Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах
Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр болон Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

ДУГААР 151011-1

ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

Тогтоол 2: Компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилох

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дох заалт, 77 дугаар зүйлийн 77.3, 77.4 дэх заалт, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04-р сарын 23-ны өдрийн ээлжит хурал ("Хурал")-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө чөлөөлж ТУЗ-ийг шинэчилсэн бүрэлдэхүүнээр томилохоор шийдвэрлэсүгэй.
2. ТУЗ-ийн ердийн гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Адилбиш овогтой Ганхуяг,
 - (ii) Адилбиш овогтой Ганболд,
 - (iii) Гансүх овогтой Бат-Эрдэнэ,
 - (iv) Очирбат овогтой Батмөнх,
 - (v) Ганболд овогтой Чинзориг,
 - (vi) Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ.
3. ТУЗ-ийн хараат бус гишүүдээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай. Үүнд:
 - (i) Нямжав овогтой Энхболд,
 - (ii) Чулуун овогтой Мэргэн,
 - (iii) Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo).
4. Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх зэрэг дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

Хурлын дарга Хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА



А.ГАНХУЯГ

ДУГААР 151011-1
ОГНОО 2022 оны 04-р сарын 23-ны өдөр

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:



ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Т.Гантулга